



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 19

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 24,050,000 (Хорин дөрвөн сая тав) төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 35-22 ДУА улсын дугаартай КАМА автомашины худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан), Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сармандах) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.МӨНХЧУЛУУН



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн  
19 дүгээр тогтоолын хавсралт



Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах хөрөнгийн мэдээлэл

| д/д             | Тээврийн хэрэгслийн төрөл | Марк | Улсын бүртгэлийн |        | Үйлдвэрлэсэн он | Ашигласан огноо | Тээврийн хэрэгслийн мэдээлэл |                |                  | Балансын үнэ                                  | Хуримтлагдсан элэгдэл                         | Үлдэгдэл өртөг | Худалдах доод үнэ             |
|-----------------|---------------------------|------|------------------|--------|-----------------|-----------------|------------------------------|----------------|------------------|---|---|----------------|-------------------------------|
|                 |                           |      | сери             | дугаар |                 |                 | Арлын дугаар                 | Моторын дугаар | Моторын эзлэхүүн |   |   |                |                               |
| 1               | Ачааны автомашин          | кама | ДУА              | 35-22  | 2016            | 2016            | 3LWU2P22C<br>2GKM01861<br>S  | D1040P<br>D3   | B2550<br>C.тоо3  | 24,050,000                                    | 24,050,000                                    | -              | 1,000,000                     |
| <b>Нийт дүн</b> |                           |      |                  |        |                 |                 |                              |                |                  | <b>25,000,000</b><br>(хорин таван сая) төгрөг | <b>25,000,000</b><br>(хорин таван сая) төгрөг |                | <b>1,000,000</b><br>(нэг сая) |